

2021 ОНЫ ХАГАС ЖИЛД ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА,
АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ГАРГАСАН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

2021.06.07

Эрдэнэдалай сум

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
1	ЗДТГ	71	45	-	-	26	63.3%
2	Эрүүл мэндийн төв	22	22	-	-	-	100%
3	Хүүхдийн цэцэрлэг	8	8	-	-	-	100%
4	ЕБС	24	5	-	-	19	21%
5	Соёлын төв	3	3	-	-	-	100%
6	Нийгмийн даалтгал	89	89	-	-	-	100%
7	Нийгмийн халамж	456	444	12	-	-	97%
8	Иргэний бүртгэл	60	56	4	-	-	100%
9	Татвар	6	6	-	-	-	100%
10	Газар зохион байгуулалт	153	40	113	-	-	100%
НИЙТ ДҮН		892	718	129		45	88.1%

2021 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРАЛД ИРГЭДЭЭС ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД
ХАНДАЖ ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ /ХЭЛБЭРЭЭР/

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдол санал хүсэлт	Үүнээс				
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
1	ЗДТГ	71	68		3	-	-
2	Эрүүл мэндийн төв	22	22	-	-	-	-
3	Хүүхдийн цэцэрлэг	8	8				-
4	ЕБС	24	24	-	-	-	-
5	Соёлын төв	3	3				-
6	Нийгмийн даалтгал	89	89	-	-	-	-
7	Нийгмийн халамж	456	322	134	-	-	-
8	Иргэний бүртгэл	60	60	-	-	-	-
9	Татвар	6	6	-	-	-	-
10	Газар зохион байгуулалт	153	153	-	-	-	-
	НИЙТ ДҮН	892	735	134	3	-	-

ӨРГӨДӨЛ ГОМДОЛ САНАЛ ХҮСЭЛТИЙН АГУУЛГА \ХУВИАР\

№	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал \тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь\			
1	Дундговь аймаг	Нийт 892 өргөдлөөс:			
		Хүсэлт	888/99.5%/		
		Санал	2/0.2%/		
		Гомдол	2/0.2%/		
		Асуудлын нэр		Нийт тоо	Нийт хувь
		Татварын үйлчилгээтэй холбоотой		6	0.6%
		Байгаль орчинтой холбоотой		11	1.2%
		Нийгмийн даатгалын үйлчилгээтэй холбоотой		89	10%
		Нийгмийн халамжийн үйлчилгээтэй холбоотой		456	51.1%
		Байгалийн гамшигт үзэгдлийн учруулсан хохиролтой холбоотой		40	4.4%
		Иргэний болон эд хөрөнгийн улсын бүртгэлтэй холбоотой		60	6.7%
		Газрын харилцаатай холбоотой		153	17.1%
		Сумын өнгө үзэмж, дэд бүтэцийг сайжруулах чиглэлээр		5	0.5%
		Сумын ТББ-ын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр		10	1.2%
		Төрийн үйлчилгээг хүргэх чиглэлээр		30	3.3%
		Малчдад чиглэсэн үйлчилгээний чиглэлээр		28	3.1%
		Бусад асуудлаар		4	0.4%

2021 хагас жилийн байдлаар нийт 892 санал, хүсэлт, өргөдөл, гомдол ирсэн байна.

Сумын өнгө үзэмж, дэд бүтэцийг сайжруулах чиглэлээр:

- Сумын төвд дутуу тавигдсан 2 км авто замаас болж машины эвдрэл гэмтэл их гарч байна гэсэн гомдлын дагуу Сумын Засаг даргын Дундговь аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, мэргэжлийн хяналтын байгууллагаар гүйцэтгэлийн үнэлгээ хийлгүүлсэн. Үнэлгээгээр уг ажлын явц 36 хувийн гүйцэтгэлтэй гүйцэтгэгч компанийн мэдүүлсэн ажлын гүйцэтгэлд хүрэхгүй байгаа тул хуулийн байгууллагад шалгуулж байна.
- Мэдээлэл холбоо сүлжээ ХХК-ын кабелийн утас шороон шуурганы улмаас тасарч машины цонх хагарсан гомдлын дагуу МХС Дундговь салбарт тоот хүргүүлж, МХС компанийн ажлын хэсэг суманд ажиллаж тасарсан, ил задгай, хэрэглэгдэхгүй болсон кабелийн утасыг хурааж сумын өнгө үзэмжийг сайжрууллаа.
- Сумын өнгө үзэмжид сөргөөр нөлөөлж, нитийн эзэмшлийн талбайд байдаг ЗДТГ-ын өмчийн харъяалал 12 айлын орон сууц, Далай ээж худалдааны төвийн түрээслэгчидтэй уулзаж барилгын өнгө үзэмжийг сайжруулах, дулаан, цэвэр, бохирын шугамтай холбох талаар хэлэлцүүлэг хийж 2021 ондоо багтаан шийдвэрлэхээр төлөвлөгөө гарган ажиллаж байна.
- Шинэ соёлын төв ашиглалтад орж иргэдээс хуучин соёлын төвийн барилгыг хэрхэн ашиглах вэ? гэсэн асуулт ихээр ирсэн тул сумын өмч хамгааллын байнгын зөвлөлөөс ажлын хэсэг байгуулагдаж Бөөний худалдааны төв байгуулах талаар гэрээний төсөл боловсруулж байна.

Сумын ТББ-ын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр:

- Сумын баялаг бүтээгч, ААН байгууллагуудын төлөөлөлтэй уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж Эрдэнэдалай сумын брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж Хот, бусад аймгийн зах зээлд нийлүүлэх, хоол үйлдвэрлэгчдийн гол тулгамдаж буй асуудал болох мах нөөцлөх асуудлыг ЗДТГ-ын дэргэдэх хөргөх зоорийг ашиглуулах зэргээр асуудлыг шийдвэрлэхээр боллоо. Мөн тогоочдын холбоо байгуулах, сумын ногоо тариалагчдаа дэмжин дотоодын худалдан авалтыг дэмжих талаар үүрэг чиглэл өгсөн.
- Сумын уяачдын холбоо, Эрдэнэдалай миний нутаг ТББ-уудын төлөөлөлтэй уулзаж тулгамдаж буй асуудлыг сонсож үүрэг чиглэл өглөө. Мөн УИХ-ын Б.Саранчимэг гишүүнтэй холбож тэргэнцэр, харааны бэрхшээлтэй иргэний таяг зэрэг нэн шаардлагатай байгаа 5 хэрэглэгдэхүүн шийдвэрлүүлж өглөө.
- Сум хөгжүүлэх сангаас зээл аваад зээлийн хэвийн төлөлтөө хийж байгаа 34 иргэн, ААНэгжийн 195.000.000 сая төгрөгийн зээлийг 2021.01.01 өдрөөс 2021.05.01-ний өдөр хүртэл хойшлуулсан.

Төрийн үйлчилгээг хүргэх чиглэлээр:

- Золбин нохой муур устгах талаар ирсэн гомдлын дагуу Улаанбаатар хотоос Баянгол дүүргийн Хот тохижуулах газраас хүн хөлсөж 154 эзэнгүй нохойг устагсан. Сумын эзэнтэй нохойны тооллого хийж 284 нохойд туулга өгч, пайзж, гэрчилгээтэй болгох, нохойны татврын хэмжээг тогтоох талаар 350 иргэнээс санал авсан.
- Шороон шуурга: 3 сарын 14 өдөр болсон шар шороон шуурганы улмаас гэр, хашаа нурсан тусламжид хамруулж өгнө үү гэсэн хүсэлтийн дагуу иргэдийн материалыг бүрдүүлж Хүүхдийг ивээх сангаас 3 гэр, 40 хүнд эрүүл ахуйн багц, 20 хүнд 100 долларын мөнгөн тусламж, Улсын онцгой комиссоос-7 гэр, Дэлхийн Зөн олон улсын байгууллагаас-1 гэр, Улаан загалмай олон улсын

байгууллагаас 1 гэр, УИХ-ын гишүүн Сү.Батболд 2 гэр нийт 14 өрхөд иж бүрэн шинэ гэрийн тусламж үзүүлсэн.

- Шороон шуурганы улмаас гудамж, талбай, лагер хороололд үүссэн их хэмжээний элс шороог зөөвөрлөж Их-Усны ухсан нүхийг нөхөн сэргээх зорилгоор дүүргэж байна. Дундговь аймгийн Онцгой байдлын газар, Дундговь аймгийн Ган-Илч ХХК, Хан дээж ХХК /Эрдэнэдалай сумын Цагаан-Овооны нүүрсний уурхай/, Сайн констракшин зэрэг компаниудын техник хэрэгслийг ашиглан зөөвөрлөж байна.

Ажилд орохыг хүссэн өргөдөл:

- ЕБС-ийн сургуулийн дотуур байрны тогоочоор Ч.Уранбаярыг ажилд авсан.
- Эрүүл мэндийн төв: Ц. Түмэндэмбэрэл 1 дүгээр багийн эмчээр, Ж. Энхзаяа нь нягтлан бодогчоор, Д. Сарантуяаг үйлчлэгчийн ажилд түр тушаалаар, Б.Оюунтуяаг Архив бичиг хэргийн ажилтнаа тус тус томилсон .
- ЗДТГ-ын няраваар Д.Анхбаяр, 7-р багийн тоо бүртгэгчээр Т.Баттөр, Хүний нөөц хэвлэл мэдээллийн ажилтанаар Э.Бат-Амьдрал, Сангууд хариуцсан нягтлангаар Т.Энхбат, 5-р Багийн Засаг даргаар М.Насанбаатар, 6-р Багийн Засаг даргаар Ц.Ган-Өлзий нар тус тус томилогдсон.

Малчдад чиглэсэн үйлчилгээний чиглэлээр:

- Отроор нүүдэллэн яваа малчдын төлөөллүүд отрын бүс нутагт хороо бууцны татвар авч байна, орон нутгийн удирдлага хөөх тохиолдол их удирдлагын түвшинд асуудлыг шийдвэрлэж өгөөч гэсэн хүсэлтийн дагуу ИТХ-ын дарга, Засаг даргаар ахлуулсан 2 ажлын хэсэг Төв аймгийн Бүрэн,

		<p>Баянжаргалан, Баян, Дорноговь аймгийн Алтанширээ, Говьсүмбэр аймгийн Баянтал, Шивээговь зэрэг 3 аймгийн 9 сумын дарга удирдлагуудтай уулзаж гэрээ хэлэлцээр хийсэн.</p> <ul style="list-style-type: none">• Малчдад хөнгөлөлттэй зээл тусламжаар өвс тэжээл олгож өгнө үү гэсэн хүсэлтийн дагуу 128 өрхөд 31.362.100 төгрөгийн өвс, тэжээл зээлээр олгоод байна. <p>Хугацаа болоогүй өргөдлийн талаарх шалтгаан: ЕБС-ийн “Багш хотхон” төсөлд хамрагдах, Мэргэжлийн зэрэг, кабинетын гэрчилгээ авах, сунгах, хүсэлтийг ирэх хичээлийн жилээс кабинетийн шалгуур үзүүлэлтийн дагуу шийдвэрлэх тул хугацаа болоогүй.</p>
--	--	--

ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА

Г.ЭНХДЭЛГЭР

НЭГТГЭСЭН:

СӨГ, ДОТООД АЖИЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Л.БОЛОРЦЭЦЭГ